



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ГАА-2024/162/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа

Утас: 99029885 Цахим хаяг: [tsania.0215@gmail.com](mailto:tsania.0215@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 01 № 12

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2048 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилт 531,131.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт 20,265.0 мянган төгрөг, хандив тусламжаар 81,782.2 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил үнэ төлбөргүй орлого авчээ.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 4 хөтөлбөр, 45 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 5 арга хэмжээг бүрэн, 34 арга хэмжээг 70.0-90.0 хувь, 5 арга хэмжээ 50.0 хувь, хэрэгжүүлээгүй 1 арга хэмжээ буюу нийт дүнгээр 81.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 78.8 хувиар, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 68.50 хувиар үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07000040

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Дансны код	Балансын зүйл	2022.12.31	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	305,199.8	283,125.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	725,354.4	746,149.4
	Нийт хөрөнгийн дүн	1,030,554.2	1,029,274.7
	Нийт өр төлбөрийн дүн	3,076.4	681,665.7
	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,027,477.8	1,028,593.0
	Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	1,030,554.2	1,029,274.7
<b>Орлого үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,459,813.3	638,468.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	593,686.2	637,352.9
	Үйл ажиллагааны үр дүн	866,127.1	1,115.2
<b>Цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийсэн үлдэгдэл	161,350.	1,027,477.8
	Тайлант оны үр дүн	866,127.1	1,115.2
	Эцсийн үлдэгдэл	1,027,477.8	1,028,593.0
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	686,874.8	552,076.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	483,801.4	575,850.2
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	203,073.4	(23,773.5)
	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(26,936.9)	(25.61362)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	0.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	176,136.5	(49,386.7)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	176,136.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	176,136.5	126,749.8
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	Нийт зарлага цэвэр зээлийн дүн		581,198.4
	Урсгал зардал		581,198.4
	Хөрөнгийн зардал		0.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		531,811.8
	Эрүүл мэндийн даатгалын сангаас		531,131.7
	Орон нутгийн төсвөөс		19,414.7
	Урьд оны үлдэгдлээс		
	Туслах үйл ажиллагааны орлогоос		680.0

**ГУРАВ АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 5,805.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.



### 3.1 Албан шаардлага

1. Эм боох материалын үлдэгдэлд хугацаа дууссан 97 нэр төрлийн 8843 ширхэг 14,726.3 мянган төгрөгийн эм бэлдмэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулан хугацаа дууссан эмийг холбогдох журмын дагуу шийдвэрлэж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2.Тендерт шалгараагүй 3 аж ахуйн нэгж байгууллагаас 5,805.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан этгээдээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

### Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Алтай сумын Эрүүл мэндийн төв	2	5.8	-	-	2	5.8	-	-	-	-	-	-	-
Дүн	2	5.8	-	-	2	5.8	-	-	-	-	-	-	-

### Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Алтай сумын Эрүүл мэндийн төв	1								1	
Дүн	-1	-	-	-	-	-	-	-	1	-

### Зургаа.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	



			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруул сан	Аудит хийгээгү й	Өөрчлөл тгүй	Хязгаар лалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			